



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Баян-Өндөр сумын урлагийн төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын Уран эгшиг сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2023/91/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Эрдэнэт хот 2023 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70359826 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70357955 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn Аудитор: Г.Даваасүрэн Утас: 70350757 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826

Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2023.08.24 № 16
танай _____ -ны № _____ -т

ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР
СУМЫН УРЛАГИЙН
ТӨРӨЛЖСӨН СУРГАЛТТАЙ
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
УРАН ЭГШИГ СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ А.ТӨГСЖАРГАЛ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Баян-Өндөр сумын урлагийн төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын Уран эгшиг сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Баян-Өндөр сумын урлагийн төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын Уран эгшиг сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орхон аймгийн Баян-Өндөр сумын урлагийн төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын Уран эгшиг сургуулийн 2022 оны санхүүгийн тайлангийн хугацаанд улсын төсвөөс 528,398.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 80,084.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас, 530,161.1 мянган төгрөгийн зардлыг зүйл ангиар зарцуулсан байна. Дээрх онцгойлсон асуудалтай холбоотой аудиторын дүгнэлт өөрчлөгдөөгүй болно.

Аудитын гол асуудал

Засгийн газрын 2022 оны 91 дүгээр "Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай" тогтоолын дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчит ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг хувьсах зардлын дундаж нормативаар буюу гүйцэтгэлд суурилан төсвийг олгож

эхэлсэн байна. Гүйцэтгэлд суурилсан төсөвтэй холбоотой жилийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 2023 онд дахин хуваарилан хэрэгжүүлэхээр үлдээсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Орхон аймгийн Баян-Өндөр сумын урлагийн төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын Уран эгшиг сургууль нь 2021 оны 4 сард байгуулагдаж өөрийн байргүйгээс шалтгаалан Орхон аймгийн 4 дүгээр сургуулийн дэргэд хөгжмийн болон уран нугаралтын анги бүхий 90 сурагчтай, 11 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж, 6 дугаар сард өөрийн байрыг хүлээн авч сургуулийн эд хөрөнгийг төвлөрүүлэх, нэн шаардлагатай засварын ажлыг хийх, багш, ажилтнаа шалгаруулж авах, нэмэлт элсэлт авах ажлыг зохион байгуулж 9 дүгээр сарын 19-ээс сургалтын үйл ажиллагаагаа хэвийн явуулж эхэлсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдээс зүй бусаар нөлөөлөх нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	14,872,600.00	69,989,708.96
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	35,711,558.10
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	35,711,558.10
3121	Төгрөг	0.00	35,711,558.10
31211	Төрийн сангийн харилцах	0.00	35,711,558.10
35	БАРАА МАТЕРИАЛ	14,872,600.00	34,278,150.86
351	Түүхий эд материал	963,500.00	27,067,700.86
35110	Тусгай зориулалттай материал	963,500.00	27,067,700.86
354	Хангамжийн материал	13,909,100.00	7,210,450.00
35410	Бичиг хэргийн материал	11,734,100.00	5,790,150.00
35420	Аж ахуйн материал	460,000.00	855,300.00
35470	Бусад хангамжийн материал	0.00	565,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,390,491,197.16	1,534,648,194.22
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,390,491,197.16	1,534,648,194.22
392	Биет хөрөнгө	1,389,858,384.66	1,136,264,131.72
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,006,696,798.00	1,006,696,798.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-78,987,610.80	-104,574,658.80
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	7,593,130.27	155,395,551.74
39206	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-40,094,535.17
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,771,127.47	147,754,762.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-66,767,656.07
39214	Бусад үндсэн хөрөнгө	432,312,050.00	42,786,950.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,527,110.28	-4,933,080.04
393	Биет бус хөрөнгө	632,812.50	398,384,062.50
39301	Програм хангамж	675,000.00	675,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-42,187.50	-210,937.50
39303	Бусад биет бус хөрөнгө	0.00	397,920,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,405,363,797.16	1,604,637,903.18
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,007,443,797.16	1,604,637,903.18
51	Засгийн газрын хувь оролцоо	1,007,443,797.16	1,604,637,903.18
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	0.00	397,920,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,007,443,797.16	1,206,717,903.18
51210	Өмнөх үеийн үр дүн	1,007,443,797.16	-893,444,391.29
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	2,100,162,294.47
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,007,443,797.16	1,604,637,903.18

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	75,253,500.00	2,679,043,970.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	2,089,837,570.35
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	2,089,837,570.35
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	6,679,385.60
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	3,450,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	2,550,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	678,585.60
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		2,042,985,583.89
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал		25,300,000.86
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	75,253,500.00	589,206,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	73,538,500.00	522,397,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,269,800.00	522,397,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,715,000.00	66,808,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,715,000.00	66,808,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	54,478,287.50	578,881,675.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	54,478,287.50	578,881,675.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	51,196,464.84	533,208,140.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	39,111,511.33	381,423,491.03
210101	Үндсэн цалин	26,808,166.75	286,918,226.92
210102	Нэмэгдэл	8,522,033.58	78,996,896.46
210104	Урамшуулал	3,589,311.00	15,508,387.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,780,866.01	46,832,570.87
210201	Тэтгэврийн даатгал	3,249,393.56	32,442,316.88
210202	Тэтгэмжийн даатгал	391,115.12	3,815,328.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	312,892.09	3,052,262.50
210204	Ажилгүйдлийн даатгал	75,224.12	677,451.99
210205	Эрүүл мэндийн даатгал	752,241.12	6,845,231.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	15,907,614.63
210301	Гэрэл, цахилгаан	0.00	4,106,466.13
210302	Түлш, халаалт	0.00	6,999,333.76
210303	Цэвэр, бохир ус	0.00	4,801,814.74
2104	Хангамж, бараа материалын зардал	2,174,900.00	10,114,750.00
210401	Бичиг хэрэг	374,900.00	5,167,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	4,946,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	17,963,750.00
210604	Урсгал засвар	0.00	17,963,750.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	3,802,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	2,057,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	1,744,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,931,187.50	57,163,763.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	6,427,290.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,889,000.00	7,670,650.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,187.50	43,065,823.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,281,822.66	45,673,535.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	16,339,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	16,339,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,281,822.66	29,334,535.37
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,281,822.66	29,334,535.37
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,012,713,597.16</u>	<u>2,100,162,294.47</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>1,012,713,597.16</u>	<u>2,100,162,294.47</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>75,253,500.00</u>	<u>595,207,200.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	6,000,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	6,000,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	6,000,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	3,450,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	2,550,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	75,253,500.00	589,206,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	73,538,500.00	522,397,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,269,800.00	522,397,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,715,000.00	66,808,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,715,000.00	66,808,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>69,308,700.00</u>	<u>529,921,401.90</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	69,308,700.00	529,921,401.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	66,026,877.34	484,247,866.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	39,111,511.33	381,423,491.03
210101	Үндсэн цалин	26,735,871.98	286,985,877.92
210102	Нэмэгдэл	8,594,328.35	78,929,225.46
210104	Урамшуулал	3,589,311.00	15,508,387.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,780,866.01	46,832,570.87
210201	Тэтгэврийн даатгал	3,249,393.56	32,442,296.88
210202	Тэтгэмжийн даатгал	391,115.12	3,815,328.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	312,892.09	3,052,262.50
210204	Ажилгүйдлийн даатгал	75,224.12	677,451.99
210205	Эрүүл мэндийн даатгал	752,241.12	6,845,231.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	15,907,614.63
210301	Гэрэл, цахилгаан	0.00	4,106,466.13
210302	Түлш, халаалт	0.00	6,999,333.76
210303	Цэвэр, бохир ус	0.00	4,801,814.74
2104	Хангамж, бараа материалын зардал	5,476,750.00	5,355,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	460,000.00	5,355,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,715,000.00	16,211,450.00
210604	Урсгал засвар	1,715,000.00	16,211,450.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	3,802,200.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	2,057,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	1,744,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,744,750.00	14,715,540.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	9,325,540.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,744,750.00	5,390,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,281,822.66	45,673,535.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	16,339,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	16,339,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,281,822.66	29,334,535.37
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,281,822.66	29,334,535.37
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,944,800.00	65,285,798.10
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	675,000.00	29,574,240.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	675,000.00	29,574,240.00
2200	Дотоод эх үүсвэрээр	675,000.00	29,574,240.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		29,574,240.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-675,000.00	-29,574,240.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	5,269,800.00	35,711,558.10
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	35,711,558.10

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	397,920,000.00	-	397,920,000.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	1,007,443,797.16	1,007,443,797.16
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	397,920,000.00	1,007,443,797.16	1,405,363,797.16
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	397,920,000.00	1,007,443,797.16	1,405,363,797.16
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	397,920,000.00	1,900,888,188.45	1,900,888,188.45
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	2,100,162,294.47	2,100,162,294.47
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	397,920,000.00	1,206,717,903.18	1,604,637,903.18

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /улсын төсөв/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	528,398,600.00	492,687,041.90	35,711,558.10	93.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	528,398,600.00	492,687,041.90	35,711,558.10	93.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	511,869,100.00	476,348,041.90	35,521,058.10	93.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	410,562,400.00	381,423,491.03	29,138,908.97	92.90
210101	Үндсэн цалин	339,183,500.00	286,918,206.92	52,265,293.08	84.59
210102	Нэмэгдэл	61,294,400.00	78,996,896.46	-17,702,496.46	128.88
210104	Урамшуулал	10,084,500.00	15,508,387.65	-5,423,887.65	153.78
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,320,400.00	46,832,570.87	4,487,829.13	91.26
210201	Тэтгэврийн даатгал	34,897,800.00	32,442,296.88	2,455,503.12	92.96
210202	Тэтгэмжийн даатгал	4,105,700.00	3,815,328.16	290,371.84	92.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,284,500.00	3,052,262.50	232,237.50	92.93
210204	Ажилгүйдлийн даатгал	821,200.00	677,451.99	143,748.01	82.50
210205	Эрүүл мэндийн даатгал	8,211,200.00	6,845,231.34	1,365,968.66	83.36
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,802,200.00	3,802,200.00	0.00	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,057,800.00	2,057,800.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,744,400.00	1,744,400.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,184,100.00	44,289,780.00	1,894,320.00	95.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,794,100.00	38,899,780.00	1,894,320.00	95.36
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,390,000.00	5,390,000.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,529,500.00	16,339,000.00	190,500.00	98.85
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,529,500.00	16,339,000.00	190,500.00	98.85
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,529,500.00	16,339,000.00	190,500.00	98.85
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	528,398,600.00	528,398,600.00	0.00	100.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	522,397,800.00	522,397,800.00	0.00	100.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	522,397,800.00	522,397,800.00	0.00	100.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,000,800.00	6,000,800.00	0.00	100.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,450,800.00	3,450,800.00	0.00	100.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,550,000.00	2,550,000.00	0.00	100.00
5	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	35,711,558.10		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.00

62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	56	53	3	94.64
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	44	41	3	93.18
620003	Үйлчлэх ажилтан	11	11	0	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	360	356	4	98.89
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	360	356	4	98.89
630001	Төрийн өмчит ЕБС	360	356	4	98.89
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	56	53	3	94.64
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	39	37	2	94.87
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	2	2	0	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	14	14	0	100.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /орон нутаг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	80,084,200.00	37,474,064.63	42,610,135.37	46.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	80,084,200.00	37,474,064.63	42,610,135.37	46.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	80,084,200.00	37,474,064.63	42,610,135.37	46.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,932,200.00	15,907,614.63	23,024,585.37	40.86
210301	Гэрэл, цахилгаан	6,875,100.00	4,106,466.13	2,768,633.87	59.73
210302	Түлш, халаалт	20,112,900.00	6,999,333.76	13,113,566.24	34.80
210303	Цэвэр, бохир ус	11,944,200.00	4,801,814.74	7,142,385.26	40.20
2104	Хангамж, бараа материалын зардал	5,355,000.00	5,355,000.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,355,000.00	5,355,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,517,000.00	16,211,450.00	305,550.00	98.15
210604	Урсгал засвар	16,517,000.00	16,211,450.00	305,550.00	98.15
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	80,084,200.00	37,474,064.63	42,610,135.37	46.79
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	80,084,200.00	37,474,064.63	42,610,135.37	46.79
320001	Орон нутгийн төсвөөс	80,084,200.00	37,474,064.63	42,610,135.37	46.79

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,550,000.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	2,550,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,550,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,550,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,550,000.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 738.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 180.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 558.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Багшийн сургалтын "Цахим хэрэглээний зардал"-д зориулсан Юнител ХХК-ны дата багцыг 9 үндсэн багшаас гадна захирал, менежер, нягтлан бодогч, нийгмийн ажилтан, нярав, архив бичиг хэрэг, зэрэг 6 албан хаагчид 180.0 мянган төгрөгийг илүү зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно:", 12.1.1-т "гар утасны зардал", Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан "цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цахим хэрэглээний зардлыг төлөвлөх хуваарилах заавар"-ын 2.4-д "дата багцыг сонгосон нөхцөлд цахим хэрэглээний нийт зардлыг нийт үндсэн багш (бүлгийн болон хөгжим, биеийн тамирын багшийн нийт тоо) тоонд хувааж тухайн хугацаанд ашиглах цахим хэрэглээний зардлын нэгжийг тооцно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

5.2 Албан шаардлага

Тус сургууль нь цайны газрын түрээсийн орлого 558.0 мянган төгрөгийг бэлнээр авч галын хор, хүрз, жоотуу зэргийг худалдан авсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 3.12-д "Эрх бүхий ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын бүртгэлийн дансанд ажлын 1 хоногт багтаан тушааж сар бүрийн эцэст зарагдсан тасалбарын бүртгэл болон орлого цуглуулсан баримтын (зарагдсан тасалбараас өөрт үлдэх хувь) тооцоог гаргаж, тайланг тушаана." 2.2-д "Төсвийн байгууллага нь арилжааны банкны төлбөрийн картын дансанд байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай бэлэн мөнгийг төрийн сангаас баталсан хязгаар/ЖМС/-ын дотор шилжүүлэн авч болох бөгөөд гадаад, дотоод албан томилолт, гадаад зочны зардал, тэтгэмж, урамшуулал, шагналыг батлагдсан төсвийн хүрээнд шилжүүлэн авч болно." 2.3-д "Журмын 2.2-д зааснаас бусад зардлаас зайлшгүй бэлнээр гүйлгээ хийлгэх шаардлагатай тохиолдолд албан хүсэлт, шаардлагатай хөрөнгийн баталсан төсөв, бэлнээр авах үндэслэлийг тодорхой тусгаж ирүүлнэ. Төрийн сан албан хүсэлтийг хянаж үзэн, шаардлагатай гэж үзвэл бэлнээр олгож болно." гэж заасныг зөрчсөн байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Жилийн эцсийн санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагад ирүүлэхдээ санхүүгийн тайлангийн тодруулгыг зохих журмын дагуу бэлтгэж тайлагнаагүй.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна.", 8.1.5-д "санхүүгийн тайлангийн тодруулга.", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 1 дүгээр хавсралтын 3.19-д "Зарлагыг хүлээн зөвшөөрч нягтлан бодох бүртгэлд тусгах талаарх санхүүгийн тайлангийн тодруулгыг холбогдох УСНББОУС-ийн дагуу хийнэ. Мөн тусгай шийдвэр, заавар журмын хэрэгжилтийг харуулах шаардлагатай бол хавсралт тайлангаар гаргана." гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайлангийн тодруулгыг холбогдох стандарт, журам, зааврын дагуу боловсруулан гаргаж хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орхон аймгийн Баян-Өндөр сумын урлагийн төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын Уран эгшиг сургууль	3	738.0	1	180.0	1	558.0	1	-				
Дүн	3	738.0	1	180.0	1	558.0	1	-				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй					
А	1	2	3	4	5	7	8	9	10	
1	ТШЗ	1	+			+				
2										
	НИЙТ	1	+			+				